

2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирлын өдөрлөгийн арга хэмжээний
талаарх мэдээ, тайлан

ШУТИС-ийн оюутнууд клубийн системээр хамтдаа хөгжин, хамтын хүчээр олон ур чадварыг хөгжүүлж бүтээн бий болгож буй явдал нь их сургуулийн сурталчилгааны томоохон үйл ажиллагааны нэг хэсэг нь Клубүүдийн үйл ажиллагааг сурталчилах клубүүдийн нэгдсэн өдөрлөгийг 10 дугаар сарын 30-нд зохион байгуулсан.

Уг үйл ажиллагааны хүрээнд клубүүд нэгдэн өдөрлөгийн бүхий л чимэглэл, анонс хэвлэл, богино хэмжээний кино гаргах зэрэг ажлуудыг хамтдаа амжилттай гүйцэтгэсэн. Мөн салбар сургууль болон клубийн танилцуулга хийсэн. Энэхүү үйл ажиллагаа нь клубүүдийн хамтын ажиллагааг сайжруулах, клубүүдийг сурталчлан таниулах, оюутнуудын идэвхи санаачлагыг нэмэгдүүлж, идэвхжүүлэх, дэмжих чухал ач холбогдолтой байсан гэж үзэж байна. Сайн дурын болон мэргэжлийн клубүүд өөрсдийн үйл ажиллагааг сурталчилах бусдад танин мэдүүлэх зорилгоор онцлог шинжүүдээ тодотгохуйц бүтээлийн үзэсгэлэнгээ гаргасан нь онцлог байлаа.



Зураг. Өдөрлөгийн чимэглэл бэлтгэлийн ажил оройн 23 цагт

Энэ ажиллагааны үеэр ШУТИС-ийн КНЗ-ийн ахлагч БАС-ийн оюутан Б.Бат-Ирээдүй болон ёс зүйн “Соёмбо” клубийн ахлагч УУИС-ийн оюутан Н.Баяраа нарыг МҮОНТ-ийн өглөөний зочны цагаар 2020 оны 10 сарын 28, 29 ны өдөр оруулж ШУТИС-ийн оюутнууд клубээр хэрхэн хөгжиж хамтран ажиллаж буй ямар үйл ажиллагаа зохион байгуулж байгаа, оюутнууд хэрхэн чадваржиж байгаа талаар дэлгэрэнгүй ярилцлага өгөв.



Зураг. КНЗ-ийн ахлагч БАС-ийн оюутан Б.Бат-Ирээдүй



Зураг. “Соёмбо” клубийн ахлагч УУИС-ийн оюутан Н.Баяраа

Өдөрлөгт дараах клубүүд оролцсон

Мэргэжлийн клуб


1. CCS клуб
2. Finde клуб
3. Inspiration клуб
4. WHIZZ клуб
5. СЭХ клуб
6. Энергетик клуб
7. Залуу экологич клуб

Сайн дурын клуб

1. AIESEC клуб
2. Хятад хэл клуб
3. Meine Zukunft клуб
4. Дуулаачийн клуб
5. Соёмбо клуб
6. Hitonin клуб
7. Empowerment клуб

8. SySCo Tech клуб
9. Зөв зохистой хооллолт клуб
10. D-Art клуб
8. Хос уянга клуб
9. Багшийн туслах оюутан клуб
10. Орос хэлний клуб
11. Шагай харваа клуб
12. English speaking club

I. Клуб тус бүр өөрсдийн клубийн сурталчилгаагаа хийж шинэ гишүүдээ бүртгэн ажиллав. Оюутнууд клубүүдийн өртөөг дамжих, стикер цуглуулах үйл ажиллагаар явагдаж, .



Зураг. Клубийн танилцуулга

Клубүүдийн үйл ажилгааг сурталчилах өдөрлөгийг нээж ШУТИС-ийн Оюутны соёл, үйлчилгээний албаны ахлах мэргэжилтэн /Ph.D/ Д.Цогзолмаа үг хэлж, урлагийн тоглолт, шилдэг дүр хувиргалтыг шалгаруулах, богино хэмжээний кино, хөгжөөнт тоглоом, циркийн үзүүлбэр үзүүлсэн. Шилдэг дүр хувиргалтыг шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Энэхүү тэмцээн эрэгтэй 9 оюутан, эмэгтэй 14 оюутан оролцож ялагчдыг тодруулж, ШУТИС брендийн гарын бэлгээр шагнасан.



Зураг. Өдөрлөгийн үйл явц

Клубүүдийн 2020-2021 оны намрын улирлын тайланг хүлээн авч үйл ажиллагаатай нь нэг бүрчлэн танилцаж хангалттай сайн ажилласан клубийн ахлагч, идэвхтэй гишүүдэд кредитийн урамшуулал олгохоор ажиллаж байна. Клубүүдийн хийсэн ажлын тайланг эмхтгэн цахимд байршуулна. Энэ өдөрлөгийн арга хэмжээг ШУТИС-ийн НБТ-ийн мэргэжилтэн н.Төгөлдөр тодорхойбичлэг хийж КНЗ-ийн ахлагч, клуб тус бүрийн ахлагч нараас бага хэмжээний шторк танилцуулга бичлэг хийж архив үүсгэсэн.

Клубүүдийн нэгдсэн зөвлөл